

“Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК-д шаардлагатай
 шууд худалдан авалтын зар №104

Тендер шалгаруулалтын дугаар: ДААТҮТӨХК/20260602435
 Төсөвт өртөг: 6,000,000 төгрөг

2026.04.16

**БАЙГАЛЬ ОРЧНЫ АЖИЛ СУРТАЛЧЛАХ, ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ
 ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ АЖЛЫН ДААЛГАВАР**

1. **Зориулалт:** Байгаль орчны менежментийн тогтолцоо ISO 14001:2015 стандартын хэрэгжилтийг хангах, үүссэн хог хаягдлыг ангилан ялгах, дахин боловсруулах мэргэжлийн байгууллагад нийлүүлэх, ажилтан албан хаагчдын хандлагыг өөрчлөх, сургалт, сурталчилгаа явуулах.
2. **Тавигдах шаардлага:**
 - Гүйцэтгэгч нь хог хаягдлын менежментийн чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлэх туршлагатай байх
 - Хог хаягдлын чиглэлээр сургалт, сурталчилгаа явуулах мэргэжлийн боловсон хүчинтэй байх
 - Хог хаягдлыг дахин боловсруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байх эсвэл дахин боловсруулдаг байгууллагатай хамтран ажилладаг байх.
3. **Хийгдэх ажлын мэдээлэл:**

№	Үзүүлэлт	Ажлын даалгавар
1	Гүйцэтгэх ажлын байршил:	Гангийн үйлдвэр, Төмөртэй, Төмөртолгой уурхай
2	Ажлын даалгаврын үндэслэл, зорилго:	Компанийн үйл ажиллагаанаас үүсэх энгийн болон аюултай хог хаягдлыг бууруулах, ангилан ялгах, дахин ашиглах, мэргэжлийн байгууллагад нийлүүлэх замаар байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн зөвлөх үйлчилгээ авах
3	Мөрдөх хууль, тогтоомж, дүрэм, журам	<ul style="list-style-type: none"> - Байгаль орчныг хамгаалах тухай хууль, - Хог хаягдлын тухай хууль - Зөрчлийн тухай хууль - Бусад холбогдох журам, норм, стандарт - Гангийн үйлдвэр, Төмөртэй, Төмөртолгой уурхайн БОМТөлөвлөгөөнд тусгагдсаны дагуу
4	Гүйцэтгэх ажлын үндсэн чиглэл:	1. Гангийн үйлдвэр, Төмөртэй, Төмөртолгой уурхайн үйл ажиллагаатай танилцаж цаашид

		<p>хог хаягдлын менежментийг сайжруулах, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар менежментийн төлөвлөгөө боловсруулан хүлээлгэн өгөх</p> <p>Үүнд: Одоогийн нөхцөл байдлын үнэлгээ</p> <ul style="list-style-type: none"> • Хог хаягдлын эх үүсвэрийг тодорхойлох • Хэмжээ, төрөл, давтамжийг судлах • Одоогийн менежментийн сул талуудыг тодорхойлох <p>Хог хаягдлын ангилал, бүртгэлийн систем</p> <ul style="list-style-type: none"> • Хог хаягдлыг ангилан ялгах талаар шинэ арга туршлагыг нэвтрүүлэх • Бүртгэл, тайлагналын аргыг сайжруулах <p>2. Ажилтан албан хаагчдад хог хаягдлыг ангилан ялгах, дахин ашиглах чиглэлээр сэтгэлгээг өөрчилсөн сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулах – 2 удаа</p> <p>3. Дахин ашиглах боломжтой хог хаягдлыг хүлээж авах, хог хаягдлыг дахин боловсруулж эцсийн бүтээгдэхүүнийг хүлээлгэн өгөх чиглэлээр хамтран ажиллах.</p> <p>Үүнд: Дахин ашиглалт ба дахин боловсруулалт</p> <ul style="list-style-type: none"> • Дахин ашиглах боломжийг тодорхойлох • Дахин боловсруулах байгууллагатай хамтран ажиллах • Хог хаягдлыг багасгах шийдлүүд санал болгох <p>4. Компанийн хог хаягдлын менежментийн дагуу хэрэгжүүлж буй ажлыг дотооддоо болон олон нийтэд сурталчлах видео контент хийх-2 удаа, цахим хэлбэрээр байршуулах</p>
5	Тавигдах үндсэн шаардлага	<ul style="list-style-type: none"> - Хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлж байсан туршлагатай. - Энэ чиглэлээр мэргэжлийн боловсон хүчинтэй байх - Хог хаягдлыг дахин боловсруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бол давуу тал болно.
6	ХАБЭА-н заавар, зааварчилгаа:	Гүйцэтгэгч ажил гүйцэтгэж байх хугацаандаа өөрийн аюулгүй байдлыг бүрэн хангаж ажиллана.
7	Ажил хүлээлцэх журам	Гүйцэтгэх ажлын үндсэн чиглэлийн дагуу хийсэн ажлын тайланг тухай бүр захиалагчид ирүүлнэ.

Жич:

- Урьдчилгаа төлбөр олгохгүй
- Төлбөрийг Ажил гүйцэтгэсэн тайлан, хүлээн авсан акт, гэрээ дүгнэсэн акт үйлдсэний дарааа, нэхэмжлэхийг үндэслэн 30 хоногийн дотор төлнө.
- Оролцогч нь баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэрт /Adobe PDF/ шилжүүлж, цахим хэлбэрээр ирүүлэх ба ирүүлсэн бүх материал тод байх шаардлагатай бөгөөд уншигдахгүй материалыг ирүүлээгүйд тооцно.

Бүрдүүлж ирүүлэх материал:

- Албан бичиг /Үнийн санал, ажил гүйцэтгэх хугацаа, төлбөрийн нөхцөлийг дурдсан байх/
- Байгууллагын гэрчилгээ, НӨАТ-ын гэрчилгээ, Татварын өргүй тухай тодорхойлолт
- Ажлын даалгавар, танилцуулга, бусад нотлох баримт

- Холбогдох мэйл хаяг, утасны дугаар

**Үнийн санал хүлээн авах сүүлийн хугацаа:
2026 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 17 цаг 00 минут хүртэл**

**Шууд худалдан авалттай холбоотой тодруулга
болон үнийн санал хүлээн авах мэйл хаяг:**

procurement2@dmp.mn

Утас/факс: 7509-0044